

Living the Lotus 4

Buddhism in Everyday Life

2025
VOL. 235



Бразилын Рисшо Косей кай

Living the Lotus Vol. 235 (2025.04)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Итгэн дээдлэх гэдэг нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Сүсэг бишрэл гэж юу вэ?

Шагжамүни бурхны мэндэлсэн өдөр бол бурхны сургаалыг сүслэн дээдлэгч хүмүүний хувьд гүнзгий утга учиртай өдөр билээ. Японд гол төлөв шинэ тооллын 4-р сарын 8-ны өдөр Шагжамүни бурхны төрсөн өдрийг тэмдэглэх ёслол болдог.

“Бүшшоо-Э ёслолоор би ч гэсэн төрөхдөө жаахан байсан гэж бодогдоно.” (Мори Сүмио) хэмээх мөрт байдаг ба энд гарч буй *Бүшшоо-Э* гэдэг нь ч, *Канбүцү-Э* (бурхан дээр амт ат цай асгах ёслол) ч, *Ханамацүри* (цэцгийн баяр) ч бүгд Шагжамүни бурхны төрсөн өдрийг тэмдэглэх баяр ёслолын нэр юм. Энэ өдөр сүм хийдэд байршуулсан цэцгээр чимэглэсэн жижигхэн дуган дахь бурхан багшийн балчир дүр дээр чихэртэй цай гоожуулан асгах үед Мори Сүмио гуай өөрийнхөө төрсөн үеийг дурсан санаж “Би ч гэсэн Шагжамүни бурхан лугаа адил эрхэм нандин амь насыг хүртсэн юм байна шүү дээ.” хэмээн ухаарч, түүнийгээ энэхүү мөртөөр илэрхийлсэн болов уу.

Шагжамүни бурхны мэндэлсэн өдрийн “Тэнгэр газар дээр цор ганц би эрхэм” гэх алдартай үгийн утга лугаа хүн болж төрснийхөө гайхамшгийг сэтгэл зүрхээрээ мэдрч, талархаж, амар амгаланг мэдрэхийн сацуу “өөрийн сэтгэл зүрх үргэлж бурхан багшийн сэтгэл зүрхтэй хамт цохилж байна” гэж мэдрэх нь “сүсэглэх сэтгэл” гэж Үүсгэн байгуулагч хэлсэн байдаг. Тиймээс энэ өдрөөр дамжуулж хүн бүр өөрийн хийгээд бусдын амь насыг нандин чухлыг ухамсарлаж, түүнд талархах нь үнэхээрийн сайхан хэрэг.

Түүнчлэн Үүсгэн байгуулагч “Хүн хэрхэн амьдарвал зохилтойг сургадаг зүйл бол сүсэг бишрэл” гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл хүний амьдрал, үзэл санаа, амьдралын хэв маягийн үндэс суурийг шашин, сүсэг бишрэл зааж сургадаг гэсэн утгатай ба түүний хамгийн наад захын ойлголт нь “өөрийн амь насыг нандин чухлыг ухамсарлаж, хүн болж төрсөндөө талархах” явдал гэж би боддог юм.

Шагжамүни бурхныг төрөөд долоо хонож байхад эх Маяа нь насан өөд болсон. Амьдралын ийм бодит үнэнийг илэрхийлэх төрөх, өтлөх, өвдөх, үхэх зовлон, орчлонгийн юмс үзэгдэл ямагт хувьсан өөрчлөгдөж байдаг (хамаг юмс мөнх бус) ба шүтэн барилдлагын харилцаа холбоонд оршдог (хамаг юмс би үгүй) гэсэн туйлын үнэнийг сайтар тунгааж, аливаа зүйлийг байгаагаар нь хүлээн авч бусадтай эв эетэй байх нь “жинхэнэ зохист амьдрал” болно.



Бурхны сургаалаас ийм амьдралын хэв маягийг сурч, өөрийн сэтгэлийг сайжруулах гол чиглүүлэгч болгон итгэн дээдэлж явахыг “сүсэг бишрэл” гэх ба үүнийг бодит амьдралдаа бүтээлчээр хэрэгжүүлэх үйл нь бидний өдөр тутамдаа хийдэг бодьсатвагийн үйл билээ.

Цаг үеийн өөрчлөлтөд автахгүй байх

Нэгэн бурхны шашинтан хүн гэр бүлийнхэнтэйгээ сүүлийн үед нийгмийн асуудал болоод байгаа хууль бус цагийн ажлын талаар ярилцжээ. Тэр хүн “залуучууд яагаад ингэж тоосон шинжгүй хулгай хийж, хүний амь хөнөөдөг байна аа?” гэж асуутал охин нь шууд л “сүсэг бишрэл байхгүй болохоор юм биш үү” гэж хариулсан гэсэн.

Сүсэг бишрэлээр дамжуулж өөрийн хийгээд бусдын амь насны нандин чухлыг ухаарч, дан ганц өөрийн хүчээр амьдардаг хүн хаана ч байхгүй гэдгийг ойлгох юм бол хэн бүхэнд байдаг нинжин сэтгэл, бусдын төлөөх сэтгэл нь сэргэж, гэмт хэрэг хийх нь байтугай харин ч эсрэгээрээ бусдад эелдэг нинжин хандах “суурь хандлага” суудаг гэсэн утга “сүсэг бишрэл бүхий гэр бүл” гэсэн “хөрс”-нд өсөж торнисон охины үгэнд нэвт шингэсэн мэт санагдана.

Гэхдээ энэ нь сүсэг бишрэлтэй байснаар муу үйл хийхгүй, ядуу зүдүү, өвчин зовлонгоос ангид байна гэсэн үг биш. Жинхэнэ зохист амьдралыг зааж сургадаг нандин сургаал буюу шашны сургаал номд итгэж, түүнийг эрхэмлэн дээдэлж амьдарснаар бид бүхэн олон зүйлийг сурч мэдэж, хүний хувьд өсөж хөгжих боломжтой гэсэн үг.

Нарийн төвөгтэй болж байгаа өнөөгийн нийгэмд шашин шүтлэг, сүсэг бишрэл ширүүхэн харцтай тулгарч байна гэгдэнэ. Гэхдээ хүний сэтгэлийн гүнд амьдралын түшиг тулгуураа болгон итгэн дээдлэх сургаалыг эрэлхийлэх сэтгэл, сурч мэдэх, өсөж дэвших хүсэл эрмэлзэл гарцаагүй байдаг. Тэр утгаараа бүх хүний дотор угаас шашинлаг сүсэг бишрэлийн сэтгэл оршдог гэж би боддог юм.

Тэгэхээр одоо хамгийн чухал зүйл бол цаг мөчийг нүд хууран аргацаан өнгөрөөх бус бурхны зам мөрийн үндэс суурь болох жинхэнэ энэрэн нигүүлсэх сэтгэлээр хүмүүстэй харилцаж, ямар нэг асуудал гарахад сэтгэлийн дэм өгч чаддаг хүн болох явдал юм. Эндээс үгээр хэлэхийн аргагүй амар амгаланг мэдэрч байвал угаас сүсэглэх сэтгэлийг тээсэн хэн бүхэн аяндаа “жинхэнэ зохист амьдрал”-аар амьдрах нь дамжиггүй.

“Косей” сэтгүүл, 4-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Нийгэмд хувь нэмэр оруулж, соёлыг өвлүүлэх нь

Ниваногийн нэрэмжит энх тайвны сан


Энх тайван нийгмийг зөвхөн нэг улс эсвэл шашин, улс төр, эдийн засгийн хүчээр бий болгох боломжгүй. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, сэтгэлгээ зэрэг олон салбарт энх тайвны төлөө зүтгэж яваа хүмүүстэй хамтарснаар амар амгалан нийгмийг бүтээж чадна. Энэ үзэл санаанд тулгуурлан Ниваногийн нэрэмжит энх тайвны сан үүсгэн байгуулагдсан.

Тус сан нь шашны үзэлд суурилдаг ба олон салбарт анхаарал хандуулж, нийгэмд тустай энх тайвны үйл ажиллагаа явуулдаг. 1978 онд Рисшо Косэй Кай нийгэмлэгийн 40 жилийн ойгоор үүсгэн

байгуулагдсан байна.

“Ниваногийн нэрэмжит энх тайвны шагнал”-ыг дотоод, гадаадын мөргөлдөөн, асуудлыг шийдвэрлэхийн төлөө бусад шашны байгууллагуудтай гар нийлэн хамтран ажилладаг хувь хүн эсвэл байгууллагад жил бүр олгодог.

Үүнээс гадна энх тайвны төлөөх үйл ажиллагаа, судалгааны байгууллагуудыг дэмжих, симпозиум зохион байгуулах, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй соёлын солилцоо зохион байгуулах зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.



Бяцхан мэдлэг


Жил бүрийн 5-р сард “Ниваногийн нэрэмжит энх тайвны шагнал” гардуулах ёслол болдог ба тус сангийн ерөнхийлөгч Нивано, шагналын эзэн хоёрын хооронд хэлэлцүүлэг өрнөж, улс орон, соёл, шашны ялгааг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ энх тайвныг тогтоох хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцдог.



* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Сургуулийн боловсрол



Рисшо Косэй Кай нийгэмлэг энэрэнгүй нинжин сэтгэлтэй хүнийг төлөвшүүлэх зорилгоор Косэй Гакуэн боловсролын хүрээлэнг байгуулсан. Тус хүрээлэнд цэцэрлэг, охид хөвгүүдийн дунд, ахлах сургууль харьяалагддаг.

Мөн Хоожю Олон улсын мэдээлэл зүйн коллеж нь буддын сургаалд үндэслэн хувь хүний онцлог чанарыг хөгжүүлэхийн зэрэгцээ нийгэмд хувь нэмэр оруулах боловсон хүчийг бэлдэх зорилгоор ажилладаг.

Косэй Гагакү уламжлалт хөгжим бүжгийн бүлгэм



Та *шёо лимбэ, хичирики, луун лимбэ* зэрэг хөгжмийн зэмсгүүдийг мэдэх үү? Эдгээр нь 1200 гаруй жилийн түүхтэй Япон хөгжмийн зэмсгүүд бөгөөд энэ уламжлалт хөгжим бүжгийг Гагакү гэж нэрлэдэг. Косэй уламжлалт хөгжим бүжгийн бүлгэм нь Гагакү урлагийг өнөөг хүртэл үе дамжуулан хөгжүүлсээр байна.

Тус бүлгэм 1950 онд үүсгэн байгуулагдсан ба удирдах төвийн ёслолын арга хэмжээнд оролцохоос гадна тогтмол концерт зохион байгуулж, сүм хийдүүдэд хүндэтгэлийн үзүүлбэр үзүүлдэг. Мөн Францын Парис, АНУ-ын Лос Анжелес, Канадын Ванкувер хотуудад Японы уламжлалт урлаг соёлыг танилцуулах тоглолт хийдэг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Шагжамүни бурхан мэндэлсэн өдрийн шүлгээс суралцах нь

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу. Догдлол, баяр баясгалан дүүрэн хаврын улирлын ид үе ирлээ. Ургамал мод нахиалж, байгаль орчин өнгөлөг, дулаахан өнгөөр алаглах үед бид амьдралын цог золбоог мэдэрдэг билээ.

Энэ сард бид Буддын шашны гурван том баярын нэг болох “Бурхан багшийн мэндэлсэн өдөр”-ийг тэмдэглэнэ. Эгэл буддын шашинтан бидний хувьд энэ өдөр бол Бурхан багш ертөнцөд мэндэлсэнд талархах сэтгэлээ гүнзгийрүүлэх боломж юм. Тэгвэл Шагжамүни бурхны мэндлээд хэлсэн “Тэнгэр газар дээр цор ганц би эрхэм” хэмээх үгнээс бид юу сурч болох вэ?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа хүн болж төрсөн хувь ерөөлөө ухамсарлан ойлгож, Шагжамүни бурхантай адил эрхэм нандин амь насыг тээж байгаа чухал үнэнийг хүн болгон бодитоор мэдрэхийн чухлыг сургалаа. Бид Шагжамүни бурхныг өөрсдөөсөө хол оршихуй гэж үзэх хандлагатай байдаг. Гэвч үнэндээ бидний дотор бурхан багш лугаа адил амь нас гэрэлтэн оршиж буйг оюун ухаандаа төсөөлөн бодох нь сүсэгтэн хүний хувьд маш чухал зүйл гэж бодож байна. Нивано ерөнхийлөгч бидэнд үргэлж “өөрийгөө хайрлаж, өөрийгөө хүндэл” гэж сургадаг нь биднийг дотроо орших бурханлаг нандин чанараа олж хараасай гэсэн хүслээс улбаатай гэж бодож байна.

Түүнчлэн Нивано ерөнхийлөгчийн сургасанчлан энэ сард үргэлж бусдын төлөө сэтгэл, нигүүлсэнгүй сэтгэлээр хүмүүстэй харилцаж, шаардлагатай үед сэтгэлийн дэм өгөхийг хичээх болно.




3 сарын 15-нд Лос-Анжелес салбарт болсон хойд Америкийн нийгэмлэгүүдийн тэргүүн, ТУЗ-ын дарга нарын хуралд оролцов.
(Акагава дарга урд эгнээний баруун талаас гурав дахь нь)

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp